



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

**Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн  
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй  
холбогдуулан авч хэрэгжүүлэх  
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.8 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/213 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт шар усны үерээс урьдчилан сэргийлэх, малчид хаваржилтыг хохирол багатай даван туулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах зорилгоор дор дурдсан байгууллага албан тушаалтад дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

1.1. Үерийн хамгаалалтын барилга байгууламжид хуримтлагдсан мөс, лаг хагшаас, хог хаягдлыг цэвэрлэх, суваг шуудуу татан усыг чөлөөлөх нэвтрэх нөхцлийг бүрдүүлж, үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулж ажиллахыг “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-т (Б.Гэрэлмаа)-т, хороодын Засаг дарга нарт;

1.2. Дүүргийн нутаг дэвсгэрт шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн хяналт шалгалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг тодорхойлон, дүгнэлтэд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, хөрөнгө оруулалтын тооцоо судалгаа, гаргахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар), Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд;

1.3. Үерийн эрсдэлтэй болон шар усны үерт өртөж болзошгүй бүсэд суурьшсан айл өрх аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг нарийвчлан гаргаж, болзошгүй эрсдэлээс өмнө газрыг чөлөөлөх, эрсдэлтэй бүсийг иргэдэд зарлах, шилжин суурьших бүсийг тогтоож, амьдрах орчныг хангасан төлөвлөлт боловсруулахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц), Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд;

1.4. Аюулт үзэгдэл, ослын үед ажиллах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай тусгай зориулалтын машин, механизм, техник хэрэгслийг худалдан авах ажиллагааг дүүрэгт эрх шилжүүлсэн тохиолдолд холбогдох хууль, журамд нийцүүлэн шуурхай зохион байгуулахыг Худалдан авах ажиллагааны алба (О.Содовжамц)-нд

1.5. Дүүргийн нутаг дэвсгэрт шар усны үерээс урьдчилан сэргийлэх мал хаваржилтыг хохирол багатай даван туулах, Гамшгаас хамгаалах албадын үйл

ажиллагааг уялдуулан зохицуулж, удирдлагыг нэгдсэн мэдээ мэдээллээр хангах үүрэг бүхий шуурхай бүлэг байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах)-т;

1.6.Шар усны үерээс урьдчилан сэргийлэх болон “Шуурхай бүлэг”-ийн үйл ажиллагааны зардлыг дүүргийн Засаг даргын нөөцөөс шийдвэрлүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т

1.7.Малчдын хаваржилтын нөхцөл байдалтай биечлэн танилцан судалгааг нарийвчлан гаргаж, хохирол багатай давах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон дэмжлэг үзүүлэх, шар усны үерт өртөж болзошгүй малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх, сэрэмжлүүлэх, малчны хотонд хүрэх цасанд боогдсон зам давааг чөлөөлөх ажлыг зохион байгуулж ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар), хороодын Засаг дарга нарт;

1.8.Дүүргийн малчдад нийслэлийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн өвс, тэжээлийг хөнгөлөлттэй үнээр олгох ажлыг зохион байгуулахыг дүүргийн Хөдөө аж ахуйн тасаг (Ё.Гэрэлцэцэг), хороодын Засаг дарга нарт;

1.9.Орон нутагт малын гоц халдварт хонины цэцэг, бог малын мялзан өвчин гарсантай холбогдуулан дүүргийн шалган нэвтрүүлэх цэгийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (Б.Батмөнх), Цагдаагийн хэлтэс (цагдаагийн хурандаа Т.Лхагвасүрэн)-т;

1.10.Дүүргийн нутаг дэвсгэр дэх мал, амьтныг халдварт болон гоц халдварт, халдваргүй, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтад бүрэн хамруулах, зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах, ариутгал халдваргүйжүүлэлт хийхийг Мал эмнэлгийн тасаг (Б.Батмөнх)-т;

1.11.Шар усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээллийг цахим мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол хүргэж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т;

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД